



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 01614

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Ажлын албаны данс
бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 4,270,000.0 /дөрвөн сая хоёр зуун далан мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба /Э.Энхзаяа/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба /Э.Энхзаяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ~~

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2019 оны 22 дугаар сарын 20 -ны
өдрийн 4/614 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалт	
								нэг бүрийн үнэ	нийт дүн	Нэр	Эх үүсвэр
1	Зурагт	Хитачи	43 инч	2019	сайн	ш	7	610,000	4,270,000	УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан	Хандив
Тоног төхөөрөмжийн дүн									4,270,000		
Нийт бүртгэх дүн									4,270,000		